

АРХАНГАЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024.12.04

№	Зорилт, бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2024 онд шаардлагатай хөрөнгө		Хүрсэн түвшин	Хувь
			Суурь түвшин /2023/	Зорилтот түвшин /2024/	Хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Эх үүсвэр		
1	2	4	5	6	7	8	9	10
НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
1.1. Соёлын биет болон биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, сурталчлах, өвлөн уламжлуулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлнэ.								
1	ЗГҮАХ-2.3.4 АЗДҮАХ-2.5.1, 2.5.7	Иргэдэд чиглэсэн музейн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	3/150	4-өөс доошгүй хөтөлбөрт 250 иргэнийг хамруулна.	-	Орон нутгийн төсөв	- Хүүхэд багачуудад уламжлалт соёлын өвийн мэдлэг олгох, уламжлалт аргаар буузыг хэрхэн хийхийг заан, түүх, өв соёлоороо бахархах, үндэсний уламжлалт зан заншлаа танин мэдэх, дээдлэн хүндлэх үзэл төлөвшүүлэх зорилготой "ЦАГААН САРЫН ХҮНДЭТГЭЛИЙН ЗООГ" сэдэвт боловсролын хөтөлбөрийн хүрээнд “МОНГОЛЧУУДЫН УЛАМЖЛАЛТ ЦАГААН САРЫН ХҮНДЭТГЭЛИЙН ЗООГ БУУЗ” тус боловсролын хөтөлбөрт Эрдэнэбулган сумын 11-р цэцэрлэгийн Д.Мэндсайхан багштай бэлтгэл бүлгийн 25 хүүхэд хамрагдав. - Монголчууд эрт дээр үеэс хуучин жилийн өвлийн адаг сарын сүүлчийн өдрийн буюу битүүний үдэш хүүхэд багачууд, томчуулын хамтаар “Алаг мэлхий өрөх” хэмээх шагай өрөх тоглоомоор наадан ирсэн сайхан уламжлалтай. Аймгийн музейгээс цагаан сарын баярыг тохиолдуулан Алаг мэлхий өрөх боловсролын ажлыг зохион явуулж, тус хөтөлбөрт Эрдэнэбулган сумын лаборатори 1-р сургуулийн С.Цэрэндолгор багштай 1г анги, Эрдэнэбулган сумын 1-р цэцэрлэгийн бэлтгэл бүлэг, 11-р	100%

						цэцэрлэгийн Булганчимэг багштай бэлтгэл бүлгийн нийт 92 хүүхдүүд хамрагдав. - Аймгийн Засаг даргын 2024 оны 05-р сарын 13-ны өдрийн А/325 тоот захирамжаар “Аялагч хүүхдүүд” түүх, соёл, танин мэдэхүйн аяллыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдан 2024 оны 05-р сарын 18-ны өдөр нээлтээ хийн Маршрут 1: Хархорин, Хөшөө цайдам, Маршрут 2: Тайхар чулуу, Хоргын тогоо чиглэлд 3 удаагийн явалтаар ахлах ангийн 976 хүүхдийг хамруулан СУГазар, Музей хамтран зохион байгууллаа. - Жил бүрийн 5-р сарын 18-нд Олон улсын музейн өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлдэг. 2024 оны Олон улсын музейн өдрийн “Музейн боловсрол, судалгааны төлөө” сэдвийн хүрээнд “Зая гэгээний өв” үзэсгэлэнг зохион байгуулж, 2024 оны 05-р сарын 18-ны өдөр нээж үзэгчдийн хүртээл болголоо. Мөн Анхдугаар Зая гэгээний мэлмий гийсний 382 жил, Заяын хүрээ үүсэн байгуулагдсаны 393 жил болон "Монгол улсад орчин цагийн Музей үүссэний 100 жил"-ийн ойг тохиолдуулан зохион байгуулж буй “Миний мэдэх Заяын хүрээ” сэдэвт гар зургийн уралдааныг 10-15, 16-18 насны ангилалд зохион байгуулж нийт 2 төрөлд 20 бүтээл ирснээс 1, 2, 3-р байранд шалгарсан сурагчдыг үнэ бүхий зүйлээр шагнаж урамшууллаа. - АРА комплекс, Архангай аймгийн Хөгжимт драмын театртай хамтран аялал жуулчлалыг нэмэгдүүлэх, хөгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Музейн дотор талын талбайд ардын язгуур урлагийн тоглолтыг 2 удаа	
--	--	--	--	--	--	---	--

						зохион байгууллаа. Тус тоглолтыг жуулчид болон инфлүүзэрүүд үзэж сонирхсон байна. - Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас жил бүрийн 11 дүгээр сард улс орон даяар зохион байгуулж буй “СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР-2024” аян нээлтийн арга хэмжээг 2024 оны 11-р сарын 01-ны өдөр амжилттай зохион байгуулж, тус сарын аяны хүрээнд бүх нийтийн соёлын боловсролыг нэмэгдүүлэх, соёлын олон талт арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөө гарган ажиллаа. Тус аяны хүрээнд: - "Заяын хүрээтэй танилцахуй" музей үзэх хөтөлбөрт ЭБСумын ерөнхий боловсролын 5 сургуулиудын сурагчид хамрагдан "ЗАЯ ГЭГЭЭНИЙ ӨВ" тусгай үзэсгэлэнг 1088 хүүхдүүд үзэж түүх, соёлын өвийн дурсгалтай танилцлаа. - Соёлын биет бус өвийг өвлөн уламжлуулах зорилготой зохион байгуулагдсан "Даалин урлахуй" сургалтыг иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэхээр Архангай аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөлийн 15 гишүүдийг сургалтын хэрэглэгдэхүүнээр ханган, үнэ төлбөргүй хамруулж, сонирхсон 10 хүн, нийт 25 хүн тус сургалтад хамрагдсан. - “Миний мэдэх Заяын хүрээ” сэдэвт танин мэдэхүйн “Алтан хонх” тэмцээнийг Ерөнхий боловсролын 5 сургуулийн дунд ангийн нийт 250 сурагчдын дунд амжилттай зохион байгууллаа. - "Сод хүмүүнээс суралцахуй" контентыг Монголын бурхан шашны гурван зулын нэг хэмээгддэг Халхын Зая бандида гэгээнтнүүдийн Гүдэн /бие	
--	--	--	--	--	--	---	--

							шүтээн/-ий тухай контент бэлтгэн музейн пэйж хуудсаар дамжуулан 6000 орчим хүмүүст хүрч олон нийтэд сурталчлан таниуллаа.	
2	ЗГҮАХ-2.6.1 АЗДҮАХ-2.5.7	“Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг сайжруулах, үндэсний хэл, бичиг үсгээ эзэмших, хамгаалах, хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх ”	20	100	-	Улсын төсөв	- Ирэх онд явагдах төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх зорилгоор байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудыг мэргэшүүлэх, чадавхижуулах зорилгоор аймгийн ЗДТГ, “Архивчдын хөгжил, сургалт арга зүйн төв”-с хамтран 2024-06-р сарын 06-07-ны өдрүүдэд зохион байгуулсан 2 өдрийн сургалтад сан хөмрөгч Б.Баатархүү хамрагдлаа. - Аймгийн Засаг даргын 2022 оны №5 тоот албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хүрээнд нийт ажилчдын монгол бичгийн мэдлэгийн түвшин тогтоох шалгалтыг зохион байгуулж, цаашид хүн тус бүрийн мэдлэгийн түвшинд тохирох сургалтыг Эрдэнэбулган сумын V сургуулийн “Монгол хэл бичгийн багш”, Монгол улсын зөвлөх багш Д.Дуламсүрэнтэй хамтран зохион байгуулан ажиллаа. Сургалтад байгууллагын нийт 10 ажилтан хамрагдсан болно.	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:
САН ХӨМРӨГЧ

Б. БААТАРХҮҮ

ХЯНАСАН:
ЗАХИРАЛ

Т. МӨНХБҮРЭН